



ДОРНОД АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорнод аймгийн Хөгжимт драмын театрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДОА-2021/38/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Чойбалсан хот

2021 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга

бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 70584203 Цахим хаяг: Bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: И.Сэмжидмаа

Утас: 70584204 Цахим хаяг: Semjidmaai@audit.gov.mn

Аудитор: С.Энхбаатар

Утас: 70584207 Цахим хаяг: Enkhbaatarsu@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ТШЗ	Төсвийн шууд захирагч
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ДОА	Дорнод аймаг



Агуулга

1.Хараат бус аудиторын дүгнэлт.....	3-4
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	11
3. Аудитын тайлан.....	12
3.1. Ерөнхий зүйл.....	12
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	12
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт	12
3.4. Материаллаг байдал	13
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	14
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	14
3.7. Шилэн дансны мэдээлэл	14
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.9. Аудитын илрүүлэлт.....	15
Залруулсан алдаа.....	15
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил.....	15
Аудитын зөвлөмж.....	16
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	16
4. Менежментийн захидал.....	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	19



1.Хараат бус аудиторын дүгнэлт



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2021.02.25 № 269

танай _____-ны № _____-т

ХӨГЖИМТ ДРАМЫН ТЕАТРЫН
ДАРГА Л.НАРАНХҮҮ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн Хөгжимт драмын театрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорнод аймгийн Хөгжимт драмын театрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн Сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Дорнод аймгийн Хөгжимт драмын театр 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөгөөр 88.1 хувьтай дүгнэгдсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн Сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

011020135



Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ





2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	267,152,695.00	306,035,992.00
33	АВЛАГА	-	1,702,920.00
335	Бусад авлага	-	1,702,920.00
3351	Байгууллагаас авах авлага		1,702,920.00
35	БАРАА МАТЕРИАЛ	267,152,695.00	304,333,072.00
351	Түүхий эд материал	147,819,320.00	180,125,259.00
35110	Тусгай зориулалттай материал	147,819,320.00	180,125,259.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	3,330,000.00	3,330,000.00
354	Хангамжийн материал	107,123,375.00	114,537,813.00



35410	Бичиг хэргийн материал	3,920,720.00	2,919,200.00
35420	Аж ахуйн материал	97,674,805.00	102,190,763.00
35470	Бусад хангамжийн материал	5,527,850.00	9,427,850.00
35600	Мал амьтад	8,880,000.00	6,340,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,463,053,540.64	4,433,421,998.72
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,463,053,540.64	4,433,421,998.72
392	Биет хөрөнгө	4,091,638,540.64	4,062,006,998.72
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,862,176,418.00	3,862,176,418.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	- 99,414,671.90	- 173,176,381.94
39203	Авто-тээврийн хэрэгсэл	41,000,000.00	41,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	- 32,666,666.76	- 36,000,000.12
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	116,580,732.00	122,645,982.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	- 72,354,006.98	- 77,487,268.72
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	182,800,000.00	216,090,090.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	- 109,639,119.12	- 128,281,125.79
39214	Бусад үндсэн хөрөнгө	535,103,287.00	580,127,717.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	- 331,947,431.60	- 345,088,431.71
393	Биет бус хөрөнгө	371,415,000.00	371,415,000.00
39301	Програм хангамж	200,000.00	200,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	- 200,000.00	- 200,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	371,415,000.00	371,415,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>4,730,206,235.64</u>	<u>4,739,457,990.72</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	<u>1,702,920.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	1,702,920.00
413	Өглөг	-	1,702,920.00
4136	Бусад өглөг	-	1,702,920.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	1,702,920.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>4,730,206,235.64</u>	<u>4,737,755,070.72</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	4,730,206,235.64	4,737,755,070.72
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	4,887,642,298.00	4,887,642,298.00
51101	Өмч: - төрийн	4,887,642,298.00	4,887,642,298.00
512	Хуримтлагдсан үр дүн	- 313,238,895.43	- 305,690,060.35
51210	Өмнөх үеийн үр дүн	- 313,238,895.43	- 313,238,895.43
51220	Тайлант үеийн үр дүн	-	7,548,835.08
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	155,802,833.07	155,802,833.07
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>4,730,206,235.64</u>	<u>4,739,457,990.72</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,045,047,290.00	1,202,118,720.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	92,507,540.00	133,594,220.00
120	Нийтлэг татварын бус орлого	92,507,540.00	133,594,220.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	92,507,540.00	133,594,220.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	70,108,000.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	22,399,540.00	133,594,220.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	952,539,750.00	1,068,524,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	165,797,250.00	46,260,000.00



Хөгжимт драмын театрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	165,797,250.00	17,550,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	28,710,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	786,742,500.00	1,022,264,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	786,742,500.00	1,022,264,500.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,013,075,763.33	1,796,494,884.92
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,013,075,763.33	1,796,494,884.92
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,002,439,697.33	1,117,639,683.67
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	630,275,925.00	721,499,932.75
210101	Үндсэн цалин	630,275,925.00	721,499,932.75
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	78,589,348.00	90,299,507.00
210201	Тэтгэврийн даатгал	55,768,151.00	61,403,666.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,563,999.00	6,566,096.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,705,299.00	7,223,960.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,141,301.00	1,444,790.00
210205	Эрүүл мэндийн даатгал	11,410,598.00	13,660,995.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	26,435,321.00	21,900,039.00
210301	Гэрэл, цахилгаан	8,172,051.00	5,132,169.00
210302	Түлш, халаалт	14,435,999.00	13,053,659.00
210303	Цэвэр, бохир ус	3,827,271.00	3,714,211.00
2104	Хангамж, бараа материалын зардал	17,852,514.00	22,131,726.00
210401	Бичиг хэрэг	931,600.00	1,678,500.00
210402	Тээвэр, шатахуун	3,600,000.00	4,200,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	952,900.00	1,186,814.00
210404	Ном, хэвлэл	496,480.00	1,501,520.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,845,928.00	1,416,642.00
210408	Бараа материал акталсны зардал	8,025,606.00	12,148,250.00
2105	Нормативт зардал	360,000.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	360,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,947,590.00	47,727,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	199,160.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	300,000.00	363,200.00
210604	Урсгал засвар	16,448,430.00	47,364,700.00
2107	Томилолт, зочны зардал	11,779,750.00	290,000.00
210702	Дотоод албан томилолт	11,779,750.00	290,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	72,834,852.00	31,183,047.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	70,926,512.00	28,985,681.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	240,000.00	240,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	335,000.00	315,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	109,040.00	450,666.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.00	33,000.00
210807	Газрын төлбөр	1,158,300.00	1,158,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	147,364,397.33	182,607,531.92
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	147,364,397.33	182,607,531.92
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,636,066.00	678,855,201.25
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,866,000.00	56,693,100.00



213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	4,380,000.00	7,730,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	4,986,000.00	48,963,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	770,066.00	11,192,101.25
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	770,066.00	11,192,101.25
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>31,971,526.67</u>	<u>16,593,835.08</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	9,045,000.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	-	9,045,000.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	- 9,045,000.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>31,971,526.67</u>	<u>7,548,835.08</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>1,022,647,750.00</u>	<u>1,068,524,500.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	70,108,000.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	70,108,000.00	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	70,108,000.00	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	70,108,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	952,539,750.00	1,068,524,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	165,797,250.00	46,260,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	165,797,250.00	17,550,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	28,710,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	786,742,500.00	1,022,264,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	786,742,500.00	1,022,264,500.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>1,022,647,750.00</u>	<u>1,068,524,500.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,022,647,750.00	1,068,524,500.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,016,391,684.00	1,001,169,298.75
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	630,275,925.00	721,499,932.75
210101	Үндсэн цалин	630,275,925.00	600,361,486.89
210102	Нэмэгдэл	-	121,138,445.86
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	78,589,348.00	90,299,507.00
210201	Тэтгэврийн даатгал	53,440,852.00	61,403,666.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,029,459.00	5,779,169.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,287,124.00	7,223,960.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,257,666.00	1,444,790.00
210205	Эрүүл мэндийн даатгал	12,574,247.00	14,447,922.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	26,435,321.00	21,900,039.00
210301	Гэрэл, цахилгаан	8,172,051.00	5,132,169.00
210302	Түлш, халаалт	14,435,999.00	13,053,659.00



210303	Цэвэр, бохир ус	3,827,271.00	3,714,211.00
2104	Хангамж, бараа материалын зардал	11,027,500.00	8,865,314.00
210401	Бичиг хэрэг	1,024,600.00	1,678,500.00
210402	Тээвэр, шатахуун	3,600,000.00	4,200,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	952,900.00	1,186,814.00
210404	Ном, хэвлэл	2,140,000.00	500,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,310,000.00	1,300,000.00
2105	Нормативт зардал	1,780,000.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,780,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	178,463,300.00	80,577,670.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	127,832,900.00	29,241,870.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	300,000.00	300,000.00
210604	Урсгал засвар	50,330,400.00	51,035,800.00
2107	Томилолт, зочны зардал	9,516,750.00	-
210702	Дотоод албан томилолт	9,516,750.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	80,303,540.00	78,026,836.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	78,395,200.00	75,829,470.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	240,000.00	240,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	335,000.00	315,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	109,040.00	450,666.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.00	33,000.00
210807	Газрын төлбөр	1,158,300.00	1,158,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,256,066.00	67,355,201.25
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,486,000.00	56,163,100.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	7,200,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	4,986,000.00	48,963,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	770,066.00	11,192,101.25
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	770,066.00	11,192,101.25
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-



2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

						/ төгрөгөөр /
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,887,642,298.00	155,802,833.07	-345,210,422.10	-	4,698,234,708.97
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,887,642,298.00	155,802,833.07	-345,210,422.10	-	4,698,234,708.97
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	31,971,526.67	-	31,971,526.67
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,887,642,298.00	155,802,833.07	-313,238,895.43	-	4,730,206,235.64
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	4,887,642,298.00	155,802,833.07	-313,238,895.43	-	4,730,206,235.64
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,887,642,298.00	155,802,833.07	-313,238,895.43	-	4,730,206,235.64
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	7,548,835.08	-	7,548,835.08
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,887,642,298.00	155,802,833.07	-305,690,060.35	-	4,737,755,070.72

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

				/ төгрөгөөр /
Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,022,264,500.00	1,022,264,500.00	
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,022,264,500.00	1,022,264,500.00	
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	973,301,400.00	962,545,038.75	
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	726,167,700.00	721,499,932.75	
210101	Үндсэн цалин	604,876,800.00	600,361,486.89	
210102	Нэмэгдэл	121,290,900.00	121,138,445.86	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	90,770,900.00	90,299,507.00	
210201	Тэтгэврийн даатгал	61,724,200.00	61,403,666.00	
210202	Тэтгэмжийн даатгал	5,809,300.00	5,779,169.00	
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,261,700.00	7,223,960.00	
210204	Ажилгүйдлийн даатгал	1,452,300.00	1,444,790.00	
210205	Эрүүл мэндийн даатгал	14,523,400.00	14,447,922.00	
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,177,000.00	21,900,039.00	
210301	Гэрэл, цахилгаан	5,600,000.00	5,132,169.00	
210302	Түлш, халаалт	13,877,000.00	13,053,659.00	
210303	Цэвэр, бохир ус	2,700,000.00	3,714,211.00	
2104	Хангамж, бараа материалын зардал	7,698,500.00	7,565,314.00	
210401	Бичиг хэрэг	1,678,500.00	1,678,500.00	
210402	Тээвэр, шатахуун	4,200,000.00	4,200,000.00	
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,320,000.00	1,186,814.00	
210404	Ном, хэвлэл	500,000.00	500,000.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	70,268,200.00	66,952,280.00	
210601	Багаж, техник, хэрэгсэл	25,000,000.00	22,906,880.00	
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	300,000.00	300,000.00	
210604	Урсгал засвар	44,968,200.00	43,745,400.00	



2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	56,219,100.00	54,327,966.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	53,949,800.00	52,130,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	240,000.00	240,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	335,000.00	315,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	470,000.00	450,666.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.00	33,000.00
210807	Газрын төлбөр	1,158,300.00	1,158,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	48,963,100.00	59,719,461.25
2132	Бусад урсгал шилжүүлэг	48,963,100.00	48,963,100.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	48,963,100.00	48,963,100.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг		10,756,361.25
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,022,264,500.00	1,022,264,500.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,022,264,500.00	1,022,264,500.00
132001	Орон нутгийн төсвөөс	1,022,264,500.00	1,022,264,500.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	79.00	79.00
650002	удирдах ажилтан	1.00	1.00
650010	гүйцэтгэх ажилтан	63.00	63.00
650011	үйлчлэх ажилтан	15.00	15.00
650012	гэрээт ажилтан	-	-

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	235,905,250.00	46,260,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	235,905,250.00	46,260,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	235,905,250.00	38,624,260.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,310,000.00	1,300,000.00
210404	Ном хэвлэл	1,640,000.00	0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,310,000.00	1,300,000.00
2105	Норматив зардал	1,780,000.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,780,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	172,463,300.00	13,625,390.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	125,032,900.00	6,334,990.00
210604	Урсгал засвар	47,430,400.00	7,290,400.00
2107	Томилолт, зочны зардал	8,016,750.00	-
210702	Дотоод албан томилолт	8,016,750.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	48,695,200.00	23,698,870.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	23,698,870.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	7,635,740.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	7,200,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	7,200,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	435,740.00
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	-	435,740.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	235,905,250.00	46,260,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	235,905,250.00	46,260,000.00



131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	165,797,250.00	17,550,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	70,108,000.00	28,710,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-



3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн Хөгжимт драмын театрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг дарга Л.Наранхүү танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд мөнгөн кассын ажиллагааны талаар өгсөн зөвлөмжийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-наас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор С.Энхбаатар хариуцаж хэрэгжүүлэв.

Дорнод аймгийн Хөгжимт драмын театрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 сарын 25-ний өдрийн 02 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Дорнод аймгийн Хөгжимт драмын театрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Соёлын үйл ажиллагааг мэргэжлийн ур чадвар, үйлчилгээний өндөр түвшинд явуулах, төсөв төслийн, хандивын хөрөнгийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах, ажилтны мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх нийгмийн баталгааг хангах.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Төсвийн шууд захирагч санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанаас 2020 онд Хөгжимт драмын театрын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж, 3293.7 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 3 зөвлөмж өгсөн байна. Өгсөн төлбөрийн акт, зөвлөмжийг хэрэгжүүлсэн байна.

Байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.



3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны жилийн эцсийн тайлангийн нийт зардлын 1,037,072.3 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 20,741.4 мянган төгрөгөөр тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2020 оны жилийн эцсийн тайлангийн нийт зардлын 1,194,569.8 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 23,891.4 мянган төгрөгөөр тооцлоо.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Дорнод аймгийн Хөгжимт драмын театрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 22,319.8 мянган төгрөгөөр буюу 1.8 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материалын хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0
Авлага	0.0	1,702.9	1,702.9
Урьдчилгаа	0.0	0.0	0
Бараа материал	267,152.7	304,333.1	37,180.4
Үндсэн хөрөнгө	4,463,053.5	4,433,422.0	-29,631.5
Нийт хөрөнгө	4,730,206.2	4,739,458.0	9,251.8
Өр төлбөр	00.0	1,702.9	1,702.9
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	4,730,206.2	4,737,755.1	7,548.9
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	4,730,206.2	4,739,458.0	9,251.8

Авлага дансны үлдэгдэл 1,702.9 мянган төгрөг болсон нь хөгжлийн бэрхшээлтэй ажилтны цалингийн орлогоос хувь хүний орлогын албан татвар суутган авсантай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 304,333.1 мянган төгрөг болж 37,180.4 мянган төгрөгөөр өссөн нь худалдан авсан 113,789.1 мянган төгрөг, шилжүүлэн өгсөн 7325.4 мянган төгрөг, хасагдсан 93850.6 мянган төгрөгийн бараа материал хасагдсанаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл буурсан нь хөрөнгө акталснаас шалтгаалжээ. Биет бус хөрөнгө нэмэгдэж хасагдаагүй байна.

Өглөг дансны үлдэгдэл 1,702.9 мянган төгрөг болсон нь хөгжлийн бэрхшээлтэй ажилтны цалингийн орлогоос хувь хүний орлогын албан татвар суутган авсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 4,737,755.1 мянган төгрөг болж 7,548.9 мянган төгрөгөөр өссөн нь элэгдлийн зардал өссөнөөс шалтгаалжээ.

Хөгжимт драмын театрын 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 157,071.4 мянган төгрөгөөр буюу 15.0 хувиар өссөн байна.



Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийн орлого байна. Энэ нь дээд шатны төсвийн захирагчаас шилжүүлэн өгсөн үндсэн хөрөнгө байна.

Нийт зардал өмнөх оноос 172,449.1 мянган төгрөгөөр буюу 17.0 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан эд хогшил урсгал засвар, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж зардал байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,119,011.5 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,119,011.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 96,747.0 мянган төгрөгөөр бууруулж 1,022,264.5 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,022,264.5 мянган төгрөгийн төсөв баталснаас 1,022,264.5 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 1,022,264.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 1,011,508.1 мянган төгрөгийг зарцуулж, 11,192.1 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,011,508.1 мянган төгрөг буюу 98.9 хувьтай байгаа нь зардлыг 11,192.1 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээ 11,192.1 мянган төгрөгөөр дутуу зарцуулагдсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 17,550.0 мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 28,710.0 мянга, нийт 46,260.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ. Үүнээс хангамж, бараа материалын зардалд 1,300.0 мянга, эд хогшил, урсгал засварын зардалд 13,625.4 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжид 23,698.9 мянга, урсгал шилжүүлгийн зардалд 7,635.7 мянга, нийт 46,260.0 мянган төгрөгийг зарцуулжээ.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.



Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 147 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 13,149.4 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлагыг биелүүлсэн байна. Аудитаар өгсөн 16,908.1 мянган төгрөгийн 2 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт							
Албан шаардлага	1	13,149.4	1	13,149.4			0
Зөвлөмж	2	16,908.1	2	16,908.1			0
Нийт дүн	3	30,057.5	3	30,057.5			0

/мянган.төг/

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 30,980.4 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 29,580.4 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, зөрчлийг давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар санхүүгийн тайланд 1,702.9 мянган төгрөгийн авлага, өглөг тусгуулж залруулга хийлгэв.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 29,580.4 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчилд 2 албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 27,877.5 мянган төгрөгийн зарлагын 2 мэдээллийг байршуулаагүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх.

2. Хөгжлийн бэрхшээлтэй 2 ажилтны цалингийн орлогоос хувь хүний орлогын албан татвар 1,702.9 мянган төгрөгийг суутган авсан нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-д “Дараах орлогыг албан татвараас чөлөөлнө:”, 22.1.2-д “хөгжлийн бэрхшээлтэй хувь хүний орлого;”, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1-д “хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулж байгаа иргэн, хуулийн этгээдийг хууль тогтоомжийн дагуу татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамруулах, ...” гэсэн заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, тохиолдсон байх, толилуулга ба тодруулга, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх.



Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 1,400.0 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Анхаарал татахуйц асуудал байхгүй гэж үзлээ.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

Зардлын данстай холбоотой асуудал

- 1.1. Илрүүлэлт: Мөнгөн касст бэлнээр хүлээн авсан 1,400.0 мянган төгрөгийн орлогыг бүртгэлийн дансанд цаг хугацаанд нь тушаагаагүй байна.
- 1.2. Эрсдэл: Төсвийн сахилга бат алдагдах
- 1.3. Өгсөн зөвлөмж: Сангийн Сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам"-ын 2.6 дахь заалтыг мөрдөж ажиллах.
- 1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Дорнод аймгийн Хөгжимт драмын театрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2020			ДОА-2021/38/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Дорнод аймгийн Хөгжимт драмын театр		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Мөнгөн касст бэлнээр хүлээн авсан 1400.0 мянган төгрөгийн орлогыг бүртгэлийн дансанд цаг хугацаанд нь тушаагаагүй байна.	1,400.0	Зөвлөмж өгөх	Дарга, Нягтлан бодогч	Л.Наранхүү, Н.Алтантуяа
2	Шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 27,877.5 мянган төгрөгийн зарлагын 2 мэдээллийг байршуулаагүй байна.	27,877.5	Албан шаардлага өгөх	Дарга, Нягтлан бодогч	Л.Наранхүү, Н.Алтантуяа
3	Хөгжлийн бэрхшээлтэй 2 ажилтны цалингийн орлогоос хувь хүний орлогын албан татвар 1,702.9 мянган төгрөгийг суутган авсан байна.	1,702.9	Албан шаардлага өгөх	Дарга, Нягтлан бодогч	Л.Наранхүү, Н.Алтантуяа
ДҮН		30,980.4			